

КОВИДЫН ДАРААХ ХҮҮХДИЙН НИЙГЭМШЛИЙГ НӨХӨН СЭРГЭЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

*С. Сосорбурам
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль,
бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

sunarawsosorburam@gmail.com

*Н. Нямдорж
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль,
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyamaa89@gmail.com

Хураангуй: Хүн бүрт өдөр тутам бусадтай харилцах хэрэгцээ шаардлага үүсч байдаг бөгөөд бид цэцэрлэг, сургууль, байгууллагад харьяалагдаж, сурч, хөдөлмөрлөж, сэтгэл мэдрэмжээ хуваалцаж оролцсоноор нийгмийн нэг гишүүн гэдгээ мэдэрч, дэг журам, соёлд суралцаж энэхүү хэрэгцээгээ хангаж байдаг. Энэ нь А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онолын 3 дахь шатны Харьяалагдах ба хайрлуулах хэрэгцээтэй холбогддог. Гэвч Ковидын улмаас хөл хорионд орж гэрийнхнээсээ өөр хүмүүстэй харилцах харилцаагаа хязгаарлуулсан хүүхдүүдийн хувьд эргээд сургуульдаа суралцахад нийгэм сэтгэл зүйн асуудал үүсч, анги хамт олон, сурагч-эцэг эх- багшийн дунд харилцааны үл ойлголцол, стресс бухимдал, хорт зуршил, дээрлэхэлт, цахим донтолтын асуудал ихэсч, хүүхдүүд өөртөө итгэлгүй дотогшоо болсон байна. Тиймд судлаачийн хувьд ковидын дараах сурагчдын нийгэмшлийн асуудлыг судалж, түүнийг нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээг санал болгож байна .

Түлхүүр үг: Нийгэмшил, хямрал, нөхөн сэргээх үйлчилгээ, суралцагч

УДИРТГАЛ

Бөмбөрцөг даяар нүүрлэсэн Ковид-19 цар тахлын улмаас 5 тивийн хүүхэд багачууд хорионд орж, боловсролын байгууллагууд үүдээ хааж, дэлхий даяар 170 сая хүүхэд хичээлд явахгүйгээр гэртээ байсан. Бүх л үзвэр үйлгээний газар, спорт заал, клуб, секц дугуйлан хаагдаж, хүүхдүүд найз нөхөдтэйгээ ч уулзаж чадахгүй, жил бүр зохион байгуулагддаг урлаг, спорт, соёлын арга хэмжээ, уралдаан тэмцээн, хэлэлцүүлгүүд хойшилж тэдний хөгжих боломж хязгаарлагдсан. Энэ талаар 2020 оны 5 сард НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн захирагч Ахим Штайнер Хүний хөгжил 1990 оноос хойш анх удаагаа энэ онд

буурах хандлагатай байгаа талаар мэдэгдэл хийсэн¹. Хүүхдийн хөгжил бол тэдний оролцоонд тулгуурлан явагдаж байдаг. Хүүхэд аливаа үйл ажиллагаанд оролцох, бусадтай харилцах, үзэл бодлоо илэрхийлэх, найз нөхөдтэйгээ уулзах, тоглох, уралдаан тэмцээнд орж өөрийгөө сорих, дугуйлан секцэд хичээллэх бүрт өөрийгөө нээж, бусдыг ойлгож, нийгэмшин хөгжиж, төлөвшиж байдаг. БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2020 онд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа”-г 2020 онд хийсэн байна². Энэ судалгаагаар сурагчид хичээл, сурлагын хоцрогдолд орсноос гадна нийгэм-сэтгэл зүйн хувьд хүнд байгааг илрүүлжээ. Тухайлбал, сурагчдын 76,8 хувь нь сэтгэл зовнилтой байна гэсэн бөгөөд 6-13 насны сурагчдад стресс, бухимдал хэвийн үзүүлэлтээс өндөр гарчээ. Сурагчдын дийлэнх нь цар тахал, хичээлийн хоцрогдол, хичээл эхлэхэд шалгалт өгөх, сургууль дээрээ эргэн очихдоо зожиг болсон байхаас сэтгэл зовниж буй гэдгээ хэлсэн байна. Гэвч Боловсролын салбарт сурагчдад үүссэн сурлагын хоцрогдлын тухай их ярьж, хүүхдийн нийгэмшлийн хоцрогдлыг орхигдуулах хандлага ажиглагдаж байна. Дан ганц хүүхдийн хичээлийн хоцрогдлыг ярих бус нийгэмшихүйн алдагдлыг хамтад нь судалж, нөхөн сэргээх нь чухал. Эдгээр нь нэг зоосны хоёр талтай адил. Бид ирээдүйн эрдэмтдийг бус эцэг эхчүүдийг бэлтгэж байгаа. Сургуулийн нийгмийн ажилтны хувьд үүнийг судлах, нөхөн сэргээх зайлшгүй хэрэгцээ тулгараад байна. Ингэснээр хүүхдүүдийн нийгмийн харилцаа эерэгжиж, стресс бухимдал тайлагдаж, тэдний идэвх оролцоо нэмэгдэж, хичээлдээ сайжирч, хамт олны уур амьсгал нэгдэн бүрэлдэх юм. хөгжилд гарсан хоцрогдлыг нөхөн сэргээхэд эцэг эх, багш, сургуулийн дэмжлэг шаардлагатай байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Нийгэмшилт нь хүн нийгмийн харилцаанд бие даан оролцох, нийгмийн үйлдлүүдийг хийх чадварыг эзэмших, нийгмээс хүлээж буй шаардлагыг биелүүлэх чадамжтай болох, нийгмийн гишүүн болон төлөвших үйл явц юм. Хүний нийгэмших үйл явц хэзээ ч дуусдаггүй бөгөөд бага болон өсвөр насанд эрчимтэй явагдаж, хижээл насанд ч үргэлжилсээр байдаг. Нийгэмшил нь хүмүүс бидэнд хоорондоо харилцах боломжийг олгох төдийгүй нийгмийг хадгалан үлдээх үүрэгтэй. Нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг нийгэмшилтийн агент гэж нэрлэдэг.

Нийгэмшилтийн тухай Хүн төрөлхтөн бид нийгэм хэмээх онцгой ёс журамтай, бие биенээсээ харилцан хамааралтай амьдардаг бөгөөд орь ганцаар насан туршдаа амьдарч өөрийнхөө биеийн болоод сэтгэл зүйн хэрэгцээг хангаж чадах амьтан биш учраас ярьж сурахаас эхлээд олон чадваруудыг

эзэмших шаардлагатай болдог энэ бүгд бол нийгэмшилт. Нийгэмд хүний ёсоор амьдрахад зайлшгүй шаардлагатай эдгээр чадвар, дадал, ухааралуудыг бид ямар нэг сургалтанд сууснаар, эсвэл хэн нэгэн хүнээс зөвлөгөө авсанаар бүгдийг өөрийн болгох боломжгүй. Харин насан туршдаа дэлгүүр орж худалдан авалт хийх, найз нөхөдтэйгөө сэтгэлээ уудлан ярилцах, эцэг эхдээ хайрлуулж үнсүүлэх зэрэг бүхий л бидний хийдэг үйл ажиллагаа, үйл хөдлөл, бусадтай харилцах харилцаагаар нийгэмшилт явагддаг. Жишээлбэл, бидний хэн нэгэн найз маань бидний сайн найз хирнээ бидэнд муу зүйл хийж, найздаа туслахгүй байх, шударга бус, хүн чанаргүй үйлдэл хийх юм бол тэр хүнийг найзын хүрээллээсээ хасч үнэнч, шударга байхыг түүнд найз нөхөд нь сануулдаг. Ийнхүү тухайн хүнийг найз нөхдийн харилцаагаараа хүртэл бид нийгэмшүүлж, нийгмийн нэгэн гишүүн байж, ая тухтай сэтгэл ханамжтай байхад нь сургаж, үлгэрлэж, энэ нийгмийн гишүүн болгон төлөвлүүлж байгаа хэрэг юм. Хүүхэд эхээс төрөхдөө шил хайлах зуухнаас гарч буй урсамхай уян шил шиг л байдаг. Ийм шилийг эдлэж, сунгаж, хэлбэржүүлж хүссэнээрээ л өөрчилж болно. Хүмүүс бид эхээс төрөхдөө бие даан амьдрахад шаардлагатай чадварыг эзэмшсэн байдаггүй харин нийгэмшилтийн ачаар өөрийн хэрэгцээг хангах чадвартай болж нийгэмд аюулгүй, амар тайван амьдрах чадвар, итгэл үнэмшилийг олж авдаг. /Хүн төрөлхтөний товч түүх номны хэсгээс / 18 Нийгэмшилтэд дараах 3 хүчин зүйл нөлөө үзүүлдэг. Үүнд:

1. Макро хүчин зүйл: Улс орны нийгмийн нөхцөл, улс үндэстэн юуг эрхэмлэн үзэж буй байдал, нийгэм, улс төрийн амьдрал хувь хүний нийгэмшилтэд нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, дарангуйллын дэглэмтэй улс оронд амьдардаг хүн чөлөөтэй сэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг хүний эрхийн наад захын ойлголт дутмаг, түүнийг амьдрал ахуйдаа хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, энэ дадал чадвар төлөвшөөгүй байх бол ардчилсан, хүний эрхийг дээдэлдэг улс оронд амьдарч буй хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой, энэ дадлыг өөртөө төлөвшүүлсэн хүн болж нийгэмшдэг. Өөрөөр хэлбэл ямар үнэт зүйлийг эрхэм болгодог, ямар дэг журамтай улс оронд амьдарч буйгаас тухайн хүний нийгэмшил хамаардаг. Иймд улс орны улс төрийн бодлого шийдвэр, хууль эрх зүйн орчин, улс төрийн дэглэм бидний амьдралд чухал нөлөөтэй.

2. Мезо хүчин зүйл: Үндэстэн угсаатны онцлог, ёс заншил, амьдарч байгаа газар, орон нутаг, суурин хэв маяг, олон нийтийн мэдээллийн сүлжээ зэрэг нь 19 хүмүүсийн нийгэмшилтэд нөлөөлдөг. Жишээлбэл, Маргарет Мидийн “Хүйс ба зан авир” номонд өгүүлсэн шинэ Гвинейн 2 өөр овгийн хүмүүсийн үзэл бодол, амьдралын хэв маягийн ялгаатай байдлаас үүнийг харж болно. Арапеш овгийнхон - тэд бол найрсаг тайван ард түмэн, дайны тухай ойлголтгүй, цэцэрлэг ургуулж, ан агнаж, хүүхдээ өсгөн хүмүүжүүлж

амьдарцгаана. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд харилцан бие биедээ туслан, гэр бүлд адил тэнцүү хариуцлага хүлээн хоёулаа сайхан сэтгэлтэй байж, бусдад туслаж байхыг зөв гэж үздэг. /Жендэрийн тэгш эрх хөгжлийн агуулга болох нь; 2008/ Тчамбули овгийнхон- энэ овогт эмэгтэйчүүд бүх ажлаа эрхлэнэ, загас барьж, даавуу нэхэж, наймаа хийдэг бол эрчүүд нь биеэ гоёж, урлагаар оролдож, баяр цэнгэл зохиохоо бодож, цагаа барна. Орон сууцыг энд эмэгтэйчүүдийн байр гэнэ. Эрчүүд нь өөрийн ёс жаягийн байрт тухлана. /Жендэрийн тэгш эрх хөгжлийн агуулга болох нь; 2008/ Ийнхүү ямар соёлтой орон нутаг, үндэстэн угсаатанд амьдарч, өсөж хөгжиж буйгаас тухайн хүний нийгэмшилт хамаардаг байна.

3. Микро түвшинд: Хүмүүстэй шууд харилцан үйлчлэлд оролцож, нийгэмшилтэд нөлөөлж байдаг хүчин зүйлс буюу гэр бүл, найз нөхдийн хүрээлэл нь мөн хүний нийгэмшилтэд нөлөө үзүүлдэг байна.

Нийгэмшилтийг тодорхойлох гол шалгуур:

- Бусдыг хүндэтгэдэг байх
- Хүрээлэн буй орчноо хайрладаг байх
- Өөрийн гэсэн үнэт зүйл, үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх
- Ухаалаг шийдвэр гаргаж чаддаг байх зэрэг

Хүн хэрхэн нийгмийн гишүүн болдог өөрөөр хэлбэл хэрхэн нийгэмшдэг талаар олон төрлийн тайлбар, онолууд байдаг. Тухайлбал,

Хэрэгцээний шатлалын онол: Хүмүүнлэгийн онолын нэрт төлөөлөгч, Америкийн сэтгэл судлаач тэрээр 1943 онд бичсэн “Сэдэлжүүлэлтийн онол” өгүүлэлдээ энэ тухай анх дурджээ. Энэ онолоор хүний анхдагч хэрэгцээ хангагдахгүй бол дараа дараагийн шатны хэрэгцээ хангагдахгүй гэж үздэг. Хүн бүрт өдөр тутам бусадтай харилцах хэрэгцээ үүсч байдаг. Цар тахлын үед хүүхдүүд хоол ундтай, гэртээ байгаад эхний 2 шатны хэрэгцээ ямар нэгэн байдлаар хангагдаж байсан боловч 3 дахь шатны Нийгмийн буюу гишүүнчлэлийн хэрэгцээ хангагдаж чадаагүй. Тэд гэр бүлээсээ өөр анги хамт олон, найзууд, клубынхэн, багийнхантайгаа уулзаж чадаагүй. Энэ хэрэгцээ хангагдаагүй тул дараагийн шатны өөрийгөө үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээндээ хүрч чадахгүй гацсан юм.



Хүний физиологийн хэрэгцээ: хүний амьдралын наад захын хэрэгцээ ордог бөгөөд түүнгүйгээр хүн амьдралаа залгах боломжгүй гэж үзсэн. (агаар, ус, орон гэр, хувцас, хоол хүнс зэрэг)

Аюулгүй байдлын хэрэгцээ: нь ямар нэгэн дайн, байгалйн гамшиг, хүчирхийллээс зайлсхийсэн хувь хүний амар амгалан байх эрмэлзлэлээс үүссэн хэрэгцээ бөгөөд даатгал, хадгаламж, тэтгэмж зэргийн хэрэгцээнүүд багтдаг. Түүнчлэн дотроо хувь хүний, санхүүгийн, эрүүл мэндийн аюулгүй байдал агуулагддаг.

Нийгмийн буюу гишүүнчлэлийн хэрэгцээ: бусадтай харьцах, өөрийгөө бусад хүмүүст хэрэгтэй гэдгийг мэдрэх, бусдаас хамааралтай оршдог гэдгийг мэдрэх хэрэгцээ юм. Үүнд нөхөрлөл, гэр бүл, хүндлэл зэргийг хамаатуулжээ

Өөрийгөө хүндлүүлэх хэрэгцээнд өөрийгөө үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх зэрэг багтах бөгөөд өөрөөр хэлбэл, өөрөө өөрийгөө үнэлэх, урамшуулах гэх мэт

Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ гэдэг нь “Би хийж чадна” гэсэн эрмэлзэл, өөртөө итгэх итгэл, өөрийгөө чадварыг бусдад харуулах гэсэн хүслээс үүдэлтэй юм.

Бие хүний хөгжлийн онол: Ч.Х.Кули. Хүмүүс орчин ертөнцтэй ихээхэн харилцан үйлдсэний үндсэн дээр төлөвшдөг. Хүмүүс өөрсдийнх нь тухай бусад хүмүүс юу бодож байгаа тухай төсөөлөлдөө үндэслэн өөрсдийн үйл байдал, үйлдлээ тодорхойлдог болохыг Ч.Х.Кули “Толинд туссан би” гэдэг ойлголтоор илэрхийлсэн байдаг. Энгийнээр хэлбэл хүн бусадтай харилцсанаар бусдаас суралцаж, нийгэмд амьдрахад шаардлагатай чадваруудыг олж авдаг гэсэн үг юм.

Психоаналитик онол: З.Фрейд. Хүнд төрөх сэрэл буюу хүсэл нь хүний соёлтой үйлдэлтэй зөрчилддөг. Нийгэмшилт бол тэрхүү сэдлийг хязгаарлагч юм. Тухайлбал, тухайн хүн их чихэр идмээр санагдах нь бидний хүсэл харин их чихэр идэж болохгүй, их идсэнээр таргалж, шүд хорхой иднэ


хэмээн их чихэр идэхийг хязгаарлах нь нийгэмшилт гэж буйгаар тайлбарлаж болно. Тодорхой хэм хэмжээг дагах замаар хүн нийгэмшдэг.

Танин мэдэхүйн хөгжлийн онол: Ж.Пиаже. Аливаа хүн дараалсан үе шатыг дамжих замаар хөгждөг. Үе шат бүрт сэтгэх чадвар нэмэгдэхийн хамт, үе шат бүхэн нь шинэ мэдлэг эзэмших аргад сургана. Г.Брим Нийгэмшилтийн үйл явц хүний бүхий л амьдралын туршид үргэлжилдэг. Гэхдээ насанд хүрэгсдийн нийгэмшилт нь хүүхдийнхээс ялгаатай байдаг. Насанд хүрэгсэд ямар нэгэн хэм хэмжээг үнэлэх чадвартай байдаг бол хүүхэд түүнийг зөвхөн эзэмшиж чадна. Насанд хүрэгчдийн нийгэмшилт нь туршлага, арга барил эзэмшихэд, харин хүүхдийнх зан төлөвийг эзэмшихэд чухал нөлөөтэй.


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааг насанд хүрэгчид болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас Google form программ ашиглан, асуулгын аргаар авч боловсруулалт хийсэн. Сурагчдаас 8, Насанд хүрэгчдээс 11 асуулгаар авсан бөгөөд судалгаанд оролцогчдын мэдээллийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт-1
ЕБС-ийн суралцагчдаас авсан судалгааны боловсруулалт
Асуулга-1



Сурагчдын хариултаас дүгнэж үзэхэд ковидын хямрал нь “Сайн нөлөө үзүүлсэн” байдал ажиглагдаж байна. Мөн “Сайн нөлөө үзүүлээгүй” гэж 41.1% хариулжээ.



Энэ графикаас харахад “Сөрөг нөлөө үзүүлээгүй” гэсэн хариулт 13.5% тай, харин бусад нь хариулт бүрт давхардсан тоогоор 10-60% сөргөөр нөлөөлсөн гэж хариулжээ.

Асуулт-3, 4

Хөл хорионд гэртээ байж, хичээллэх үед чамд ямар байсан бэ?		Чи тэр үед юу хийхийг хүсдэг байсан бэ?	
Муухай, хүнд, хэцүү	66,9%	Найзуудтайгаа уулзах	52,5%
Гоё, дажгүй байсан	4%	Танхимаар хичээллэх	21%
Энгийн, зүгээр байсан	3,5%	Агаарт гарах, гадуур гарах	11%
Хичээллээ ойлгохгүй	8%	Дугуйлан секцэд явахыг	13,7%
Уйтгартай	5%	Унтахыг	3%
Найзуудаа санаж байсан	12	Тоглохыг	5,1%

Үүнээс дүгнэж хэлэхэд ковидын хямралын үед гэртээ байх нь сурагчдад, муухай, уйтгартай байсан бөгөөд тэд найзуудаа санаж, уулзахыг хүсч байжээ. Энэ нь тэдэнд нийгмийн харилцаа их дутагдсаныг илтгэж байна.

Асуулт-5

Суралцагчид		Насанд х Үрэгчид	
Нийт	504 хүүхэд	Нийт	152 хүн

Дүүрэг	Сбд - 87,8% Бзд - 4,8% Чд - 4,2%	Боловсрол	Дээд – 65.8% Бүрэн дунд – 19.7% Бүрэн бус дунд – 12% Техник мэргэжлийн – 1.7%
Хүйс	Эрэгтэй - 40,9% Эмэгтэй - 59,1%	Хүйс	Эрэгтэй – 22 % Эмэгтэй – 78 %
Анги	Бага – 13,3% Дунд – 67,9% Ахлах – 19%	Нас	20-30 21,7% 31-40 37,8% 41-50 26,9% 51-с дээш 13,7%

Одоо чанд ямар хэрэгцээ байна вэ?

315 person




Одоо тэдэнд цар тахлаас үүдэлтэй сурлагын болон хөгжлийн хоцрогдлоо нөхөх шаардлага илүү их тулгарч, мөн ярилцах, зөвлөгөө авах хэрэгцээ үүссэн байна.

Насанд хүрэгчдээс авсан судалгааны боловсруулалт
Асуулт-1

Таны амьтаснаар "Сондын үнэмлэл, нэл корно суралдын бие махбод, сэтгэл зүй, оюун ухаан"

Зөв чанд амьдралын хэв маяг нөлөөлсөн үү?

122 person




Үүнээс харахад “Огт нөлөөлөөгүй” гэж 122 хүнээс 1 хүн л хариулж, бусад нь нөлөөлсөн гэдгийг хүлээн зөвшөөрсөн хариулт өгчээ.

"Нөлөөлсөн" бол дараах зүйлсээс алинд нь илүү нөлөөлсөн бэ?
152 person




Хариултаас үзэхэд Сэтгэл хөдлөл, мэдрэмжээс бусад бие хүний бүх талуудад харилцан адилхан нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна.

Таны бодлоор БИЕ МАХБОД-ын хувьд сурагчдад ямар өөрчлөлтүүд гарсан бэ?
152 person



Графикаас сурагчдын бие махбодод таргалалт, хараа муудах, ядрах, дархлаа сулрах шинжүүд илүү их илэрсэн байна.

Таны бодлоор сурагчдын АМЬДРАЛЫН ХӨГЖ МАНГ-г ховдод өмрөлж сүргэн нөлөөлсөн бэ?
152 person




Амьдралын хэв маягийн хувьд цахим хэрэглээ ихэсч, ноёрны хэмнэл алдагдаж, суралцах арга барил болон нийгэмд биеэ авч явах соёл өөрчлөгдсөн гэсэн хариултууд их хувьтай харагдаж байна.

Асуулт-5



Асуулт-6


Асуулт-7





Судалгаанд оролцогчид сөрөг мэдрэмжүүдийг илүү их сонгосон байна.

Асуулт-9



Насанд хүрэгчид хүүхдүүдийн нийгэмшлийн хоцрогдлыг нөхөхийн тулд Хичээлээс гадуурх урлаг спортын арга хэмжээ зохион байгуулж, мөн эдгээр олон талт үйл ажиллагаануудыг явуулах нь зүйтэй гэж бүгдийг нь ойролцоо хувьтай хариулсан байна.

ДҮГНЭЛТ

Хүн бол нийгмийн амьтан. Тиймээс А.Маслоугийн Хэрэгцээний шатлалын онолын дагуу хүүхдийн харьяалагдах ба хайрлуулах буюу нийгмийн гишүүн гэдгээ мэдрэх хэрэгцээг хангахад хамтран ажиллах шаардлага тулгарч байна. Энэ хэрэгцээг аяндаа нөхөгдөнө гэж хүлээх бус боловсролын харилцаанд оролцогч талууд зориудаар нөхөн сэргээх үйл ажиллагаа, системтэйгээр зохион байгуулах нь зүйтэй. Нийгэмшлийн алдагдлыг нийгэм, хамт олон дотор нөхөн сэргээх боломжтой. Сургууль дээр хүүхдийг төлөвшүүлж, нийгэмшүүлэх хичээлээс гадуурх ажлыг ихэнхдээ

сургуулийн нийгмийн ажилтнууд хариуцдаг. Тиймээс суралцагчдын бие махбод, амьдралын хэмнэл, зан чанар, сэтгэл зүйд гарсан өөрчлөлтүүдийг эргэж хэвийн байдалд оруулахад анги удирдсан багш, нийгмийн ажилтан, эцэг эхчүүд санаа нэгдэн хамтран ажиллаж чадвал амжилтад хүрэх нь гарцаагүй. Судалгааны хүрээнд дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Боловсролын байгууллагын түвшинд:

- Сурагчдын санал бодлыг сонсох аян өрнүүлж, хүсэл сонирхлоо онлайнаар болон бусад арга замаар илэрхийлэх боломжийг олгох
- Саналуудыг нэгтгэж, боломжит саналуудыг дэмжин, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагчдад үе хоорондын ялгааг таниулах, шинэ үеийн хүүхдүүдийн онцлогын талаар сургалт, өдөрлөг хийх
- АУБ, нийгмийн ажилтан, эцэг эхчүүд хамтран ажиллах
- Дугуйлан секцийн тоог нэмэгдүүлж, төлбөрийг хөнгөлөх
- Харилцаа, зан чанарт нөлөөлөх нөлөөллийн ажил зохион байгуулах

Дүүрэг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн түвшинд:

- Сурагчдын дунд зохион байгуулагддаг уламжлал болсон урлаг, спортын арга хэмжээнүүдийг сэргээх
- Дугуйлан секц хичээллүүлж буй багш нарыг дэмжих, сургалтын төлбөрт хязгаар тогтоож, олон хүүхэд хамруулж буй хувь хүн, байгууллагыг урамшуулах

Боловсролын яам болон үндэсний хэмжээнд:

- Нийгэм сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх үндэсний судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулах
- Сургуулийн нийгмийн ажилтанд төлөвшил хүмүүжлийн хичээл заах цагийг гаргаж өгч, хуваарьт оруулах
- Нийгмийн ажилтан бэлтгэж буй их дээд сургуулиуд багшлах эрхтэй төгсгөх эрх зүйн орчныг бүрдүүлэх

НОМ ЗҮЙ

[1] О.Мягмар, М.Нямдорж. *З.Ариунбилэг. Б.Сүх-Очир Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил. 2002*

[2] О.Мягмар, М. Нямдорж. *Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил. УБ.:2002.*

[3] О. Мягмар. *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. УБ.:2010*

[4] О. Мягмар. *Хувийн зохицон дасахуй. УБ.:2000*

[5] *Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн экспертүүдийн гаргасан зөвлөмж. 2010 он*

[6] *Хүүхэд хамгааллын үндэс. УБ хот. 2009 он.*

[7] *Хүүхэд хамгааллын үйлчилгээ. УБ хот. 2010 он*

[8] *Хүүхэд хамгааллын стратеги. Үндэсний хөтөлбөр. УБ хот. 2012 он*

[9] *Э.Вэст. Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоо. УБ.: 2008.10х –33х*

[10] *Сургуулийн нийгмийн ажлын өнөөгийн байдал. Тайлан. УБ хот. 2013*